

Насан туршдаа суралцахуйн салбар дундын түншлэл хариуцсан мэргэжилтэн, Лхамсүрэн Эрдэнэчимэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих хууль тогтоомж, бодлого, шийдвэр, арга хэмжээний хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах							
1	Насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтныг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо	3	1	1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр НТСТ-ийн багш, удирдах ажилтны цахим ур чадварыг дээшлүүлж, цахим сургалт зохион байгуулах арга зүй, ур чадварыг сайжруулах зорилгоор “Мэдлэ” цахим сургуультай хамтран “Хосолсон сургалтын арга зүй сургалт”-ын бэлтгэл ажлыг ханган оролцогчдын мэдээллийг шинэчилж, 148 багшид мэдлэ хаяг шинээр нээж, 2025.01.22-2025.06.13-ны өдөр хүртэл синхрон, асинхрон хэлбэрээр, 6 бүсээр сургалтыг зохион байгууллаа. Сургалтын явцад оролцогчид болон сургагч багш нартай хамтран ажиллаж, удирдлага, зохион байгуулалт,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

				зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллав. Тус сургалтад 21 аймаг, 9 дүүргийн НТСТ-ийн нийт 556 багш, удирдах ажилтан хамрагдаж хосолсон сургалтын арга зүйн шийдэл, цахим сургалтын талбар бэлтгэх, цахим сургалт зохион байгуулах арга зүй, ур чадвараа дээшлүүлэв. Сургалтыг онлайн сургалт зохион байгуулах арга техник, суралцагчдын ялгаатай байдлыг судлах, цахим орчин дахь ёс зүй, цахим иргэн, суралцахуйн шинэ онол, загвар, зарчим, программ хэрэгсэлтэй танилцах, ашиглах, цахим анги үүсгэн удирдах, цахим орчинд бие даан сурах арга барилаа дээшлүүлэх боломж, цахим сургалтын агуулга боловсруулах, ээлжит хичээлийн хэрэглэгдэхүүнийг тодорхойлох, тохиромжтой ээлжит хичээлтэй холбох, интерактив хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг агуулгын хүрээнд зохион байгуулж сургалтад идэвхтэй хамрагдаж хосолсон сургалтын арга зүйд өөрийн удирдлагатай суралцсан 409 (73.6%) оролцогчид батламж олгосон. 2. НҮБ-ын Хүн амын сантай хамтран хүний Папиллома вирус, өвчлөлийн шалтгаан, халдварын эсрэг		
--	--	--	--	---	--	--

					дархлаажуулалт болон вакцины талаарх буруу, ташаа ойлголтыг залруулах, сүүлийн үеийн мэдээлэл өгөх сургалтыг нийслэлийн 9 дүүргийн НТС-н төвийн багш, удирдах ажилтнуудад /нийт 54 хүн/ 2025.03.11-ний өдөр зохион байгууллаа. Уг сургалтаар нийт оролцогчид ХПВ-ийн эсрэг дархлаажуулалт, түүний ач холбогдлын талаар нэгдсэн ойлголттой болж, тухайн төвүүдээс 2025 онд бүх насны иргэдэд зохион байгуулах сургалт, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах арга замыг тодорхойлж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Хавсралт: 19 файл		
1.2. Иргэдийн насан туршийн суралцахуйн асуудлаар салбар дундын уялдаа холбоог хангах, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх							
2	Насан туршдаа суралцах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо	5 байгууллагатай хамтран ажилласан.	2	1. АХБ-ны санхүүжилтээр "Мэдлэ" цахим сургуультай хамтран "Хосолсон сургалтын арга зүй сургалт"-ыг зохион байгуулж 556 багш, удирдах ажилтныг хамруулж, 409 оролцогчид батламж олгов. 2. НҮБ-ын Хүн амын сантай хамтран "Хүний Папиллома вирус, өвчлөлийн шалтгаан, халдварын эсрэг дархлаажуулалт сургалт"-ыг нийслэлийн 9 дүүргийн НТСТ-ийн 54 багш, удирдах ажилтанд зохион байгуулав. 3. СЗХ-оос	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр боловсруулан гаргасан 34 цуврал гарын авлага, постер, сургалтын материалыг НТСТ-үүдэд түгээж сургалтын материал хэрэглэгдэхүүнээр хангав. 4. "Бага насны хүүхдийн цогц хөгжил" эцэг эхтэй ажиллах сургагч багш бэлтгэх /нийт 60 багш/ сургалтын хөтөлбөрийн санал, төсвийн төсөл, бэлтгэл ажлын төлөвлөгөө, санхүүжилт хүсэх бичгийг боловсруулан НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлж, 50.076.000 төгрөгийн санхүүжилтийг зөвшөөрүүлэв. 5. "Холт интернэшнл" ОУБ-ын дэмжлэгээр "Халуун хоол" хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж НТС-н 5 төвийн нийт 245 суралцагчийг хамруулж байгаа бөгөөд хамтарсан уулзалт зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов. 6. НТС-н сургалтын хөтөлбөрт иргэний ёс зүй, зан төлөвийн боловсрол, ёс суртахуун төлөвшлийн агуулга туссан байдал болон үйл ажиллагааны тоон мэдээллийг боловсруулж АТГ-т хүргүүлэв. 7. Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарт НТСТ-ийг бие даасан хэлбэрээр байгуулж хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хамтран	
--	--	--	--	--	---	--

					ажиллах тухай албан бичиг боловсруулан хүргүүлж төрийн өмчит, хуулийн этгээд болоход дэмжлэг үзүүлэв. 8. БОУАӨЯ, БОМСТ-өөс зохион байгуулсан "Үндэсний тодорхойлсон хувь нэмэр"-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэлэлцүүлэг, Дэлхийн банк, ЦХХХЯ-аас хэрэгжүүлсэн "Үндэсний цахим элч" хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн уулзалт, Герман улсын Насанд хүрэгчдийн холбооны Төв Азийн бүсийн захирал Galina Veramejchuk, БХАН, "Бүх нийт боловсролын төлөө хамтдаа" ТББ-ын төлөөлөл, HWPL олон улсын байгууллагатай хамтарсан уулзалтад зэрэгт оролцож НТС-н бодлого, чиглэлийн талаар санал солилцов. Хавсралт: 8 файл		
3	Аймаг, дүүрэг, сумдын Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн туслах	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 4 төвд зөвлөн тусалсан.	2	1. 2025 оны 02 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулсан "Насан туршийн суралцахуйн төвийн хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг"-ээс гарсан санал, дүгнэлтийн дагуу аймаг, дүүргийн НТСТ-ийн захиралд мэргэшлийн зэрэг /Тэргүүлэх/ алгасан олгох эсэх асуудлыг судалж, холбогдох баримт бичигт үндэслэн танилцуулга бэлтгэж, НТСТ-ийн удирдах	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				ажилтны мэдээлэл солилцох уулзалтаар танилцуулж, мэдээллээр ханган ажиллав. 2. Аймаг, дүүргийн НТСТ-ийн захирлуудын 2025 оны 1, 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээний баг байгуулах тушаалын төсөл боловсруулан БЕГ-ын даргын 2025.03.20-ны өдрийн А/75, 2025.05.30-ны өдрийн А/147 дугаар тушаалаар тус тус батлуулж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллан, ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангаж, НТСТ-үүдээс тайланг хүлээн авч, үнэлэх ажлыг зохион байгуулав. Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн 29 захирал гүйцэтгэлийн тайлангаа ирүүлж үнэлгээнд хамрагдсан бөгөөд үнэлгээний үр дүнг БЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/102 дугаар тушаалаар баталгаажуулж, захирал тус бүрд албаны и-мэйл хаягаар хүргүүлсэн. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр мэдээлэл солилцох цахим уулзалтын цагаар 2025 оны 1 дүгээр улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээг танилцуулж, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөв. 3. Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар	
--	--	--	--	--	--

					сарын 30-ны өдрийн А/274 дүгээр тушаалаар батлагдсан “Насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/87 дугаар тушаалын дагуу баримт бичгийг магадлан шалгах, дүгнэлт гаргах ажлын хэсгийн гишүүнээр ажиллав. Төлөвлөгөөний дагуу аймаг, дүүргийн НТСТ-ээс мэргэшлийн зэрэг шинээр горилсон болон баталгаажуулахаар хүсэлтээ ирүүлсэн 6 багш, удирдах ажилтныг материалтай танилцаж, шалгуурын дагуу магадлан, дүгнэлт гаргав. Хавсралт: 6 файл		
4	Суралцагч аймаг, дүүргийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах	Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн төвийн тоо	3 төвийн туршлага солилцсон.	2	1. БНХАУ-ын Шанхай хотод "Суралцагч хот"-ын чиглэлээр туршлага судалсан багийн гишүүн БГД-ийн НТСТ-ийн захирал Б.Гэрэлгуа, БЕГ-ын мэргэжилтэн С.Алдармаа нартай холбогдож "Суралцагч хотыг бий болгох хэрэгцээ, шаардлага, улс орнуудын сайн туршлага", "Суралцагч хотыг хэрэгжүүлж буй Баянгол дүүргийн туршлага, гаралтын баримт бичиг"-ийн талаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

					НТСТ-ийн удирдах ажилтнуудад танилцуулга, мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулав. 2. ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, түүнд нэгдэх үйл явц, шалгуур, шаардлага, хяналт-үнэлгээний механизм болон сайн туршлага, техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулах "Суралцагч хот-хүний нөөцийг чадавхжуулах сургалт"-ын удирдамжид санал өгч БЯ-ны НТСХ-тэй хамтран ажиллав. Мөн ЮНЕСКО-ийн МҮК-ын төлөөлөлтэй уулзаж, санал солилцон "Суралцагч хот" үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Насан туршийн суралцахуйн төвүүдийн талаар мэдээлэл өгөв. 3. 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын биелэлт, үр дүнг танилцуулах цахим уулзалтын бэлтгэл ажлыг ханган зорилт 5 буюу "Салбар дундын түншлэлийг хөгжүүлэх, түншлэгч байгууллагууд, олон нийтийн оролцоотой хамтран суралцагч хот, суралцагч байгууллагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх" чиглэлээр үндэсний хэмжээнд болон нийслэл, орон нутагт Насан туршийн суралцахуйн төвөөр дамжуулан зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан,	
--	--	--	--	--	---	--

					мэдээллийг нэгтгэж илтгэл бэлтгэв. Мөн Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн "Суралцагч Орхон аймаг" үйл ажиллагаанд орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагчдын дэмжлэг, төрийн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцооны талаарх сайн туршлагыг 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын биелэлт, үр дүнг танилцуулах цахим уулзалтаар танилцуулж, түгээн дэлгэрүүлэв. Хавсралт: 5 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
5	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Биелэлтийн хувь	100%	100%	1. Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 2.2, 2.4, 4.1 дэх заалтын дагуу төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. 2. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Боловсролын ерөнхий газрын даргатай байгуулсан СХОГ-2024/285 дугаартай “Насан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					туршийн боловсролын багшийн хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах гэрээ"-нд заасан насан туршийн суралцахуйн чиглэлээрх 4 арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, гэрээ дүгнэх актыг санхүүжүүлэгч байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу боловсруулан, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулан, АХБ-ны төслийн нэгж болон БЯ-ны СХОГ-т хүргүүлж ажлыг эцэслэв. 3. Насан туршийн суралцахуйн хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэж хэлтсийн даргад хүргүүлэв. 4. 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын биелэлтийг "Салбар дундын түншлэлийг хөгжүүлэх, түншлэгч байгууллагууд, олон нийтийн оролцоотой хамтран суралцагч хот, суралцагч байгууллагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд хэрэгжилтийн талаарх илтгэл мэдээлэл бэлтгэж, хичээлийн жилийн хаалтын цахим уулзалтын бэлтгэл ханган зохион байгуулав. 5. Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр 15-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын	
--	--	--	--	--	---	--

					хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн 1 дүгээр сургуулийн түвшинд гүйцэтгэлийн үнэлгээний удирдлага зохион байгуулалт, үйл явц, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж, хөндлөнгийн хянагчаар ажиллав. Тус сургуулийн хэмжээнд нийт 52 багш гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж, 1650 суралцагч бичгийн болон цахим шалгалт өгч, үнэлгээний асуулгад нийт 945 эцэг эх, 430 суралцагч хамрагдахаас 942 (99.69%) эцэг эх, 430 (100%) суралцагч оролцлоо. Хавсралт: 10 файл		
6	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Биелэлтийн хувь	100%	100%	Өдөр тутмын үйл ажиллагаандаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байна. Мөн ХАСХОМ-ийг үнэн зөв, цаг хугацаанд нь бөглөж илгээсэн бөгөөд ЭБАТ-аар баталгаажуулав. Өдөр тутамд боловсруулж буй баримт бичиг, тушаал, удирдамжийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж холбогдох албан тушаалтнуудын гарын үсгээр баталгаажуулан цаг хугацаанд нь хүргүүлсэн. Иргэд, байгууллагаас ирүүлсэн 1 албан бичгийг цаг хугацаанд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				нь шийдвэрлэсэн. Хамтын ажиллагааны хүрээнд 2 албан бичиг боловсруулж ер системээр илгээсэн. Тушаалын төсөл 5-ыг боловсруулсан. Удирдлагаас өгсөн шуурхай үүрэг, даалгаврыг биелүүлэх чиглэлээр: 1. Хэлтсийн дотоод ажлыг 2025 оны 3 дугаар сард хариуцан ажиллаж, 7 хоног бүрийн мэдээ, тайлан, сарын ажлын тайланг боловсруулан хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэв. 2. НТСТ-Мэдээлэл солилцох цахим уулзалтыг 3 удаа зохион байгуулав. 3. Төв аймгийн боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнуудын захиалгат сургалтад НТБХ-ээс өгөх мэдээллийг нэгтгэн боловсруулав. 4. СТХЗГ-т НТСТ-ийн захирал, нягтлан бодогч нарын мэдээллийг нэгтгэн боловсруулж өгөв. 5. Бүсчилсэн хөгжлийн баруун бүсийн зөвлөгөөний боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж салбар хуралдаанд танилцуулах НТСТ-үүдийн сургалт, нөлөөллийн ажлын тоон мэдээллийг бэлтгэж БЯ-д хүргүүлэв. 6. Боловсролын ерөнхий хуульд НТС-н талаар тусгагдсан нийт 11 заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг заалт тус бүрээр боловсруулан Үндэсний	
--	--	--	--	---	--

					аудитын газрын холбогдох мэргэжилтэнд хүргүүлэв. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр БЕГ-ын СТХЗГ-т энэ талаар дахин тодруулга мэдээлэл өгөв. 7. ТАЗ-ийн БЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан шалгалтын комисс /Багахангай дүүрэг, Хэнтий, Ховд, Говьсүмбэр аймгийн НТСТ-ийн төсвийн шууд захирагчийн албан тушаалын сонгон шалгаруулалт/-ын гишүүнээр ажиллаж, нийт 2 ажлын байранд 2 хүн бүртгүүлснээс шаардлага хангасан 1 төвийн /Говьсүмбэр аймаг/ захирлын сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Хавсралт: 9 файл	
--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Эрх боловсролын зүйн чиглэлээр бакалаврын түвшний сургалтад хамрагдах /3 жил/	Сургалтын хөтөлбөрийн дагуу судалсан хичээлийн кредит цаг	1.5 жил суралцсан.	14	Эрх зүйн чиглэлээр бакалаврын түвшний сургалтад хамрагдаж дараах агуулгаар нийт 14 кредит цагийн хичээлийг танхимын болон цахим хэлбэрээр судлан мэдлэг, боловсролоо дээшлүүлэв. Үүнд: - Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /тусгай анги/ - Монгол Улсын Захиргааны эрх зүй /тусгай анги/ - Арилжааны эрх зүй - Татварын эрх зүй - Олон улсын нийтийн эрх зүй Хавсралт: 2 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр байгууллагаас зохион байгуулж буй сургалт, уулзалтад хамрагдах	Хамрагдсан сургалт, семинар, уулзалтын тоо	5 сургалтад хамрагдсан.	1	1. Төрийн жинхэнэ албан хаагчийн "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг" (ХАСХОМ) шинэчлэн гаргах тухай мэдээлэл солилцох уулзалт, сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хамрагдав. 2. МУБИС-ийн БСС-ийн Насан туршийн боловсролын тэнхимээс зохион байгуулсан "Насанд хүрсэн суралцагч" сургалтад хамрагдаж, онол арга зүйн мэдлэгээ дээшлүүлэв. 3. HWPL байгууллагын зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцаж, 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр цахимаар зохион байгуулсан "Олон улсын энх тайвны сургагч багш нарын нэгдсэн хурал-2025"-д оролцов. 4. ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, түүнд нэгдэх үйл явц,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					шалгуур, шаардлага, хяналт-үнэлгээний механизм болон сайн туршлага, техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор ЮНЕСКО-ийн МҮК, Боловсролын яам хамтран зохион байгуулсан "Суралцагч хот- хүний нөөцийг чадавхжуулах сургалт"-д 2025 оны 04 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд хамрагдаж мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэв. 5. ЗУГ-аас 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан албан томилолт, гэрээ байгуулах, ажлын хөлс олгох, санхүүгийн баримт бүрдүүлэхтэй холбоотой мэдээлэл өгөх сургалт, 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 2023 оны шинэчилсэн найруулгатай холбоотой мэдээлэл өгөх сургалтад тус тус хамрагдаж мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэв. 6. Боловсролын үнэлгээний төвөөс 2025 оны 05 дугаар 07-ны өдөр зохион байгуулсан "Гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт"-ын чиглүүлэг өгөх сургалтад хамрагдаж Дархан-Уул аймагт ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангав. Хавсралт: 14 файл	
--	--	--	--	--	---	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Насан туршдаа суралцахуйн салбар дундын түншлэл хариуцсан мэргэжилтэн, Лхамсүрэн Эрдэнэчимэг /...../
Огноо: 2025.06 сар